

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/137/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/174
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2021 19020537

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	137,238,072.50	185,936,036.28
33	АВЛАГА	9,443,434.00	33,848,093.00
335	Бусад авлага	9,443,434.00	33,848,093.00
3351	Байгууллагаас авах авлага	9,443,434.00	33,848,093.00
35	БАРАА МАТЕРИАЛ	127,794,638.50	152,087,943.28
351	Түүхий эд материал	3,796,393.18	4,485,184.09
35110	Тусгай зориулалттай материал	1,845,200.00	1,845,200.00
35130	Эм боох материал	1,951,193.18	2,639,984.09
354	Хангамжийн материал	123,998,245.32	147,602,759.19
35410	Бичиг хэргийн материал	4,368,074.91	6,090,574.91
35420	Аж ахуйн материал	3,882,649.00	4,602,062.00
35450	Барилгын засварын материал	343,000.00	9,121,454.00
35460	Хүнсний материал	00.00	623,500.00
35470	Бусад хангамжийн материал	115,404,521.41	127,165,168.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,679,115,448.36	2,794,812,609.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,679,115,448.36	2,794,812,609.59
392	Биет хөрөнгө	2,492,565,448.36	2,608,262,609.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,532,589,205.63	2,712,589,205.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	-139,610,196.00	-209,415,294.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,600,000.00	9,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,600,000.00	-9,600,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	169,566,329.19	180,234,031.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-140,073,857.26	-142,074,097.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,609,515.58	132,431,434.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	-100,459,111.85	-108,954,129.55
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,925,262.00	36,925,262.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,807,621.81	-15,079,365.45
39217	Ном	20,825,922.88	21,605,562.88
393	Биет бус хөрөнгө	186,550,000.00	186,550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	186,550,000.00	186,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,816,353,520.86	2,980,748,645.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,816,353,520.86	2,980,748,645.87
51	Засгийн газрын хувь оролцоо	2,816,353,520.86	2,980,748,645.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,572,659,707.02	2,572,659,707.02
51101	Өмч: - төрийн	2,572,659,707.02	2,572,659,707.02
512	Хуримтлагдсан үр дүн	-851,268,375.28	-686,873,250.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-851,268,375.28	-823,545,425.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	136,672,175.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,094,962,189.12	1,094,962,189.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,816,353,520.86	2,980,748,645.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,416,593,195.94	1,599,365,329.97	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,938,745.94	217,117,125.97	
120	Нийтлэг татварын бус орлого	24,938,745.94	217,117,125.97	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,440,352.94	217,117,125.97	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,440,352.94	217,117,125.97	
120009	Бусад орлого	1,498,393.00	00.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,153,150.00	258,923,504.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,127,501,300.00	1,123,324,700.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,897,550.00	104,921,304.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,092,300.00	104,831,304.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,805,250.00	90,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	155,255,600.00	154,002,200.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	155,255,600.00	154,002,200.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,481,129,559.75	1,462,693,154.96	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,481,129,559.75	1,462,693,154.96	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,287,889,998.83	1,307,453,849.41	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	902,851,558.94	908,579,726.74	
210101	Үндсэн цалин	576,822,558.00	584,428,304.65	
210102	Нэмэгдэл	201,184,700.00	235,996,498.29	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,360,000.00	27,283,083.38	
210104	Урамшуулал	94,484,300.94	60,871,840.42	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,770,599.14	114,614,812.71	
210201	Тэтгэврийн даатгал	80,733,258.96	80,332,258.59	
210202	Тэтгэмжийн даатгал	8,301,028.59	8,787,009.66	
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,633,882.86	7,006,630.81	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,658,745.71	1,710,310.87	
210205	Эрүүл мэндийн даатгал	15,443,683.02	16,778,602.78	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,273,707.00	147,444,706.00	
210301	Гэрэл, цахилгаан	7,968,637.00	7,506,606.00	
210302	Түлш, халаалт	131,191,770.00	139,938,100.00	
210303	Цэвэр, бохир ус	113,300.00	00.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	5,196,699.00	6,247,726.09	
210401	Бичиг хэрэг	1,498,891.00	918,504.00	
210402	Тээвэр, шатахуун	921,250.00	500,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	412,500.00	
210404	Ном, хэвлэл	00.00	1,260.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	160,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	515,310.00	1,508,755.00	
210408	Бараа материал акталсны зардал	1,461,248.00	2,746,707.09	

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	21,930,165.00	22,963,172.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,188,425.00	1,258,248.00
210502	Хоол, хүнс	17,935,740.00	19,150,982.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,806,000.00	2,553,942.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,276,662.00	3,381,800.00
210604	Урсгал засвар	5,276,662.00	3,381,800.00
2107	Томилолт, зочны зардал	151,500.00	223,000.00
210702	Дотоод албан томилолт	151,500.00	223,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,933,400.00	242,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,933,400.00	242,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,505,707.75	103,756,905.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	504,340.00	1,402,478.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,248,720.00	4,466,770.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,752,647.75	97,887,657.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,239,560.92	155,239,305.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	127,363,578.00	135,742,810.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,693,278.00	38,624,510.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	80,392,100.00	64,483,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,700,200.00	31,879,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	578,000.00	755,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,875,982.92	19,496,495.55
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,875,982.92	19,496,495.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-64,536,363.81	136,672,175.01
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,043,955.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,043,955.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,043,955.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-65,580,318.81	136,672,175.01

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,386,109,707.02	315,417,786.00	-297,934,384.61	2,403,593,108.42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,386,109,707.02	315,417,786.00	-297,934,384.61	2,403,593,108.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-30,963,043.50	-30,963,043.50
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,572,659,707.02	1,094,962,189.12	-851,268,375.28	2,816,353,520.86
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,572,659,707.02	1,094,962,189.12	-851,268,375.28	2,816,353,520.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	27,722,950.00	27,722,950.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,572,659,707.02	1,094,962,189.12	-823,545,425.28	2,844,076,470.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	136,672,175.01	136,672,175.01
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,572,659,707.02	1,094,962,189.12	-686,873,250.27	2,980,748,645.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,395,916,063.00	1,384,756,370.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,395,916,063.00	1,384,756,370.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,127,501,300.00	1,123,324,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	113,159,163.00	107,429,470.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,092,300.00	104,831,304.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,066,863.00	2,598,166.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	155,255,600.00	154,002,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	155,255,600.00	154,002,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,391,348,363.00	1,374,677,170.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,391,348,363.00	1,374,677,170.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,196,462,730.08	1,218,755,282.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	902,851,558.94	908,579,726.74
210101	Үндсэн цалин	576,822,558.00	584,428,304.65
210102	Нэмэгдэл	201,184,700.00	235,996,498.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,360,000.00	27,283,083.38
210104	Урамшуулал	94,484,300.94	60,871,840.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,770,599.14	114,614,812.71
210201	Тэтгэврийн даатгал	80,733,258.96	80,332,258.59
210202	Тэтгэмжийн даатгал	8,301,028.59	8,787,009.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,633,882.86	7,006,630.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,658,745.71	1,710,310.87
210205	Эрүүл мэндийн даатгал	15,443,683.02	16,778,602.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,911,990.00	146,634,581.00
210301	Гэрэл, цахилгаан	7,606,920.00	6,696,481.00
210302	Түлш, халаалт	131,191,770.00	139,938,100.00
210303	Цэвэр, бохир ус	113,300.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,321,850.00	7,773,284.00
210401	Бичиг хэрэг	378,000.00	918,504.00
210402	Тээвэр, шатахуун	905,150.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	412,500.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,260.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,073,700.00	5,781,020.00
2105	Нормативт зардал	19,800,270.00	22,691,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	525,000.00	600,000.00
210502	Хоол, хүнс	17,933,270.00	19,091,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,342,000.00	3,000,000.00

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,449,662.00	3,200,000.00
210604	Урсгал засвар	5,449,662.00	3,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	151,500.00	223,000.00
210702	Дотоод албан томилолт	151,500.00	223,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,674,400.00	6,980,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,674,400.00	6,980,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,530,900.00	8,057,978.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,100.00	1,699,958.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,442,800.00	6,358,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	194,885,632.92	155,921,887.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	129,009,650.00	136,425,392.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,996,850.00	39,307,092.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	80,392,100.00	64,483,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,700,200.00	31,879,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.00	755,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,875,982.92	19,496,495.55
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,875,982.92	19,496,495.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,567,700.00</u>	<u>10,079,200.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>4,567,700.00</u>	<u>10,079,200.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>4,567,700.00</u>	<u>10,079,200.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	4,567,700.00	10,079,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,567,700.00	10,079,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4,567,700.00</u>	<u>-10,079,200.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,277,326,900.0	1,260,428,570.5	16,898,329.6	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,277,326,900.0	1,260,428,570.5	16,898,329.6	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,232,895,200.0	1,220,365,978.5	12,529,221.6	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	908,842,400.0	908,579,726.7	262,673.3	100.0
210101	Үндсэн цалин	584,515,100.0	584,428,304.7	86,795.4	100.0
210102	Нэмэгдэл	236,017,400.0	235,996,498.3	20,901.7	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,324,000.0	27,283,083.4	40,916.6	99.9
210104	Урамшуулал	60,985,900.0	60,871,840.4	114,059.6	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,693,700.0	114,614,812.7	8,078,887.3	93.4
210201	Тэтгэврийн даатгал	86,340,000.0	80,332,258.6	6,007,741.4	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,088,400.0	8,787,009.7	301,390.3	96.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,270,700.0	7,006,630.8	264,069.2	96.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,817,600.0	1,710,310.9	107,289.1	94.1
210205	Эрүүл мэндийн даатгал	18,177,000.0	16,778,602.8	1,398,397.2	92.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,802,200.0	146,634,581.0	4,167,619.0	97.2
210301	Гэрэл, цахилгаан	10,124,100.0	6,351,167.0	3,772,933.0	62.7
210302	Түлш, халаалт	139,938,100.0	140,283,414.0	(345,314.0)	100.2
210303	Цэвэр, бохир ус	740,000.0	-	740,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	9,395,000.0	9,395,000.0	-	100.0
210401	Бичиг хэрэг	450,000.0	450,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.0	500,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.0	750,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	335,000.0	335,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.0	160,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,200,000.0	7,200,000.0	-	100.0
2105	Нормативт зардал	22,691,900.0	22,691,900.0	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,000.0	600,000.0	-	100.0
210502	Хоол, хүнс	19,091,900.0	19,091,900.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.0	3,000,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.0	3,200,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	3,200,000.0	3,200,000.0	-	100.0

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	223,000.0	223,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	223,000.0	223,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,000,000.0	6,980,000.0	20,000.0	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,000,000.0	6,980,000.0	20,000.0	99.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,047,000.0	8,046,958.0	42.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,000.0	1,699,958.0	42.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,347,000.0	6,347,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,431,700.0	40,062,592.0	4,369,108.0	90.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,431,700.0	40,062,592.0	4,369,108.0	90.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,511,200.0	39,307,092.0	4,204,108.0	90.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.0	755,500.0	165,000.0	82.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,277,326,900.0	1,260,428,570.5	16,898,329.6	98.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,123,324,700.0	1,110,593,989.5	12,730,710.6	98.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,123,324,700.0	1,110,593,989.5	12,730,710.6	98.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	154,002,200.0	149,834,581.0	4,167,619.0	97.3
132001	Орон нутгийн төсвөөс	154,002,200.0	149,834,581.0	4,167,619.0	97.3
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	71.0	71.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	48.0	48.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	22.0	22.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,831,304.00	104,831,304.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,831,304.00	104,831,304.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,468,504.00	8,468,504.00
2104	Хангамж, бараа материалын зардал	468,504.00	468,504.00
210401	Бичиг хэрэг	468,504.00	468,504.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	8,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,362,800.00	96,362,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,362,800.00	96,362,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,483,700.00	64,483,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,879,100.00	31,879,100.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	104,831,304.00	104,831,304.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,831,304.00	104,831,304.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,831,304.00	104,831,304.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэх, ур чадварын нэмэгдлийг ажлын гүйцэтгэлээр тооцож олгох, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дах Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих төлөвших үй явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг эх асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэхийг эрхэм зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/20 дугаар тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 онд 12 ажил хийхээр төлөвлөн, хэрэгжилтийн ханган, улирал бүр тайлагнаж ажилласан.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 1,277,326.9 мянга төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,159.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 14,369.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 1,277,326.9 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 104,831.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 13,74,677.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 180,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 22,882.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9,922.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 779.6 мянган төгрөгийн ном, нийт 213,584.8 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 10,079.2 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 203,505.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 13,611.7 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 81,297.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 70,615.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 33,848.1 мянган төгрөгийн авлагатай, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Энэ нь Шүүхийн шийдвэрийн дагуу хувь хүнээс авах авлага байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 152,087.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,794,812.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	9,443.4	33,848.1	24,404.7
Урьдчилгаа			-
Бараа материал	127,794.6	152,087.9	24,293.3
Үндсэн хөрөнгө	2,679,115.5	2,794,812.6	115,697.2
Нийт хөрөнгө	2,816,353.5	2,980,748.6	164,395.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,816,353.5	2,980,748.6	164,395.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,816,353.5	2,980,748.6	164,395.1

Бараа материалын дансны үлдэгдэл 33,848.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 24,404.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,794,812.6 мянган төгрөг болж 24,293.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,980,748.6 мянган төгрөг болж 164,395.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,277,326.9 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,277,326.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 1,277,326.9 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 1,260,428.6 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 16,898.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,260,428.6 мянган төгрөг буюу 98.7 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 104,831.3 мянган төгрөг төвлөрч, урсгал шилжүүлэгт 96,362.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 8,468.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 180,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 22,882.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9,922.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 779.6 мянган төгрөгийн ном, нийт 213,584.8 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 10,079.2 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 203,505.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 104/ШШ2020/00241 дүгээр шүүгчийн захирамжаар хариуцагч Э.Цэхшадаас үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн 36,356.3 мянган төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуульд олгохоор шийдвэрлэснийг тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагаар бүртгэн тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 116 нэр төрлийн 124,272.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 17 нэр төрлийн 9,062.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэсэн, сургуулийн багш, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл цалин олгохдоо тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл тайланг баталгаажуулдаггүй, ижил төрлийн тайлан, ажлын гүйцэтгэлээр давхар тушаал гаргаж, ажлын гүйцэтгэл үр дүнг бодитоор үнэлэхгүйгээр ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 176 мэдээллээс 173 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 190,337.0 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 886.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 46,037.3 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 143,413.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 886.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Захирлын 2021 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн Б/35 дугаар тушаалаар НББ-ийн тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулсан 1 албан хаагчид 1 сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн 886.4 мянган төгрөгөөр шагнаж цалингийн сангаас тоцон олгосон нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1.7 дахь заалтыг зөрчсөн, мөн журмын 3.3-дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийн дагуу хувь хүнээс авах 33,848.1 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн шүүхийн шийдвэрийн дагуу үүссэн авлагыг барагдуулж, улсын төсвийн орлогод төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Сургуулийн багш, албан хаагчдад 12,188.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин олгохдоо тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл тайланг баталгаажуулдаггүй, ижил төрлийн тайлан, ажлын гүйцэтгэлээр давхар тушаал гаргаж, ажлын гүйцэтгэл үр дүнг бодитоор үнэлэхгүйгээр ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарн 01-ний өдрийн А/35,А/10/9 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-тэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгож байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 116 нэр төрлийн 124,272.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлүүлэх

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 17 нэр төрлийн 9,062.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоолын 1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн анги доторхи зүйлийг НББОУС-д нийцүүлэн зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэхийг дарга, захирал нарт даалгасугай” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 176 мэдээлэл мэдээлэхээс 173 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн хуулийн 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 10,079.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.4-д “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон

ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийг хэмнэлттэй байхаар зарцуулж, дээд шатны байгууллагын баталсан тушаал, шийдвэрийг мөрдөн ажиллаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль	7	190,337.0	-	-	1	886.4	2	46,037.3	4	143,413.3

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn